



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

Иргэний нисэхийн багц дүрмийн
бүртгэлийн дэвтрийн загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалт, 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн Хавсралтууд, стандарт, зөвлөмжийн шаардлагыг хэрэгжүүлэх, иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор САА 6601-Maintenance Training and Experience Logbook (Техник үйлчилгээний сургалт болон дадлага туршлагын бүртгэлийн дэвтэр загвар)-ыг нэгдүгээр хавсралтаар, САА 6501-Air Traffic Service logbook (Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний бүртгэлийн дэвтэр загвар)-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бүртгэлийн дэвтрүүдийг инженер, техникийн болон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглуулах ажлыг зохион байгуулахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Ё.Эрдэнэбат/, Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хэлтэс /Д.Цогтсайхан/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба /С.Манлай/-нд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН

08 0349